

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 06-ны өдөр

Дугаар БА-070/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 38 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар 1 блок 45 (дөчин тав) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 50 (тавь) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 сарын 27-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/06/30 огноо, 0013098 БАЗГ2023/408 дугаар,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ХП-01/23

2.3. Захиалагч: Баганат өргөө ХХК оноосон нэр, 9011010145 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2562618 регистрийн дугаар, БУ17-544/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 6 дугаар хороо, 13-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 77-р байр, 5 давхар өөрийн байр, 77067777 холбоо барих утас, info@baganaturquu.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Баганат өргөө ХХК оноосон нэр, 9011010145 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2562618 регистрийн дугаар, БУ17-544/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 6 дугаар хороо, 13-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 77-р байр, 5 давхар өөрийн байр, 77067777 холбоо барих утас, info@baganaturquu.mn цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Грийн кастл ХХК оноосон нэр, 9011660139 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6174841 регистрийн дугаар, БУ18-722/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 6 дугаар хороо, Нүхт 14 - 236 тоот, 80110677 холбоо барих утас;

Нью элеватор тех ХХК оноосон нэр, 9011716080 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6259995 регистрийн дугаар, ӨБ17-501/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 7 дугаар хороо Мон-лаа 12, 16 тоот, 88113528 холбоо барих утас,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Харш прожект ХХК оноосон нэр, 9011125033 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2675633 регистрийн дугаар, ЗТ12-897/18 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 8 дугаар хороо, 4-р хороолол, 7-1 тоот, 99114877 холбоо барих утас, puba.const@gmail.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Баганат өргөө ХХК оноосон нэр, 9011010145 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2562618 регистрийн дугаартай, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, 13-р хороолол Энхтайваны өргөн чөлөө 77-р байр, 5 давхар өөрийн байр, 77067777 холбоо барих утас, info@baganaturguu.mn цахим хаяг;

Баганат харш ХХК оноосон нэр, 9011425125 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5734525 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс Баганат өргөө ХХК-ийн байр, 88113218 холбоо барих утас, baganatkharsh@gmail.com цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:


- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар 1 блок 45 (дөчин тав) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 50 (тавь) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:



- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар 1 блок 45 (дөчин тав) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 50 (тавь) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Баганат өргөө ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

(А.Мөнгөн)

(Б.Тамир)

УЛААНБААТАР ХОТ ТТБ 1584

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 2025 02 701 06
Огноо: 2025.02.06 сар ... өдөр
Бүртгэсэн: О.Мунуу
УЛААНБААТАР ХОТ ТТБ 1584

ТЭГШЭГДЭГ
АШИГЛАЛТАНД

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 38 ДУГААР ХОРОО, БАГАНАТ ӨРГӨӨ ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, 45 ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГ БҮХИЙ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 50 АЙЛЫН
ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Баганат өргөө ХХК-ийн захиалгатай, 45 ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 50 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1-р давхарт 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга: Баганат өргөө ХХК-ийн Төслийн менежер
А.Батнавч
3. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн улсын ахлах байцаагч
Ж.Жүгдэрмаа
4. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандартын Хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч
З.Очирпүрэв
5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Зүүн түгээх төв Ахлах инженер
Б.Оргил
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер
Б.Дашдорж
7. Ус сувгийн удирдах газар, Зүүн Хэрэглэгчид үйлчлэх төвийн Менежер
Ө.Шинэцэцэг
8. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Технологи удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Н.Даваадэмид
9. Онцгой байдлын ерөнхий газар Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа
М.Батсайхан
10. Барилгын хөгжлийн төв Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
Д.Батням
11. Ашиглалт хариуцагч Баганат харш ХХК-ийн Гүйцэтгэх захирал
О.Түмэнбаяр
12. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын ахлах архивч
Б.Оюунжаргал
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан
Д.Ганбат
14. Зураг төсөл зохиогч Харш Проект ХХК -ийн захирал
Н.Мөнхбат

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

А.Мөнгөн

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан–15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Баганат өргөө ХХК-ийн захиалгатай, 75 ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 50 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Цэцэрлэгийн хэсгийн ариун цэврийн өрөөний шугам сүлжээг далдалсан хайрцаг /плита/-нуудад мөн радиаторт хаалт хамгаалалт хийж хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах
- Орон сууцны хэсгийн тагтны шалны өнгөлгөө гүйцээх, айлуудын тагтны хаалга угсарсан фото акт үзүүлэх, зургийн дагуу бус тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч тайлбар ирүүлэх, ашиглалтын баталгааг НХШГ-т албан бичгээр хандах
- Авторын болон захиалагчийн дүгнэлтийг баяжуулан дүрмийн дагуу бичихдээ өмнө өгсөн хяналтын үр дүн бетон,арматурын лабораторын шинжилгээний дүн зураг төслийн шаардлагад нийцсэн эсэхийг тодорхой баяжуулж зураг төсөлд өөрчлөлт орсон бол гүйцэтгэлийн зураг боловсруулсан талаар бичиж хянуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулаан цэвэр усны худаг цэвэрлэх
- Цэцэрлэгийн гал тогооны зоонт, угаагуур угсарч дуусгах
- Халаах хэрэгслийн булангуудад зөөлөвч хийж өгөх
- Гадна дулаан, ЦБУ-ны шугам мэдээллийн санд актаар оруулах
- Барилгын холигч насосны узелээс ундны усны шинжилгээ авч НЭМГ-ын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах
- Нэгдсэн хог хаях сав хийх
- Дотор халаалт цэвэр усны шугаманд хэрэглэсэн материалын чанарын гэрчилгээ сертификат шалгуулах
- Шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д хариуцуулах
- Зуны улиралд ХХУ-ны шийдэл



Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер **Б.Дашдорж**:

- Гадна цахилгааны гүйцэтгэлийн бичиг баримт, залгах зөвшөөрөл шалгуулах
- 0.4квт-ын ерөнхий шитийн хаалганд хаяг, бичиг тавих

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Зүүн түгээх төв ахлах инженер **Б.Оргил**:

- Холигч насосны узелийн шугам, тоног төхөөрөмжийг ашиглалтын шаардлага хангасан хэвлэмэл материалаар хаягжуулах
- 485/2024 тоот техникийн нөхцөлийн 6.2-т заасан нэмэлт эх үүсвэрийг цаашид төлөвлөж төслийн хугацаанд ашиглалтанд оруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах

Ус сувгийн удирдах газар, Зүүн ХҮТ, менежер **Ө.Шинэцэцэг**:

- Усны шинжилгээ өгөх
- Цэвэр усны гадна худгийг цэвэрлэх
- БУХ-ийн шатыг бэхлэх, дулаалгыг, тагийг солих
- Цэцэрлэгт тос баригч суурилуулах
- Зөвлөмж: Гаднаас В1 давхар буюу дулааны өрөөрүү нэвтрэх хэсэгт бороо уснаас хамгаалах дээвэр, сааруулагч хийж хамгаалах
- Зөвлөмж: Хөрс, борооны усыг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх
- Зөвлөмж: Дараагийн төлөвлөлтийн барилгыг гадна ЦУХ-т гадна галын гидранд төлөвлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах боломжтой.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Технологи удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид**:

- Зоорийн давхрын кабель шугамын тавиур хийх
- Давхрын холбооны самбарын тоноглол бүрэн хийж, доторх кабель шугамыг цэгцэлж бирк зүүн хаягжуулах
- Галын системийн утаа мэдрэгчүүдийг бүрэн ажилд оруулах
- Зураг төслийн дагуу домофон системийг хийж гүйцэтгэх
- Камерын дэлгэц хянах системийг харуул хамгаалалттай нэгдсэн байранд байрлуулан хянах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газар Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа **М.Батсайхан**:

- Зоорь, 1, 2-р давхар өөрчлөлтийн зураг төсөл хянуулах
- Галын дохиолол мэдээлэгч хүлээн авах станцыг хүн 24 цаг байрлах өрөө тасалгаанд байрлуулах

- Зоорийн давхарт буусан шатыг тусгаарлах хаалт хаалга хийх
- 1-р давхрын 1-р бүлгийн өрөөг аваарын 2-р гарцтай болгох
- Цахилгааны ерөнхий шитний өрөөнд бие даасан гал унтраах автомат төхөөрөмж хийх
- 1-2, 3-12 давхрын гадна дулаалга материалын гал тэсвэржилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт нөхөж үзүүлэх
- Шаталтын бүтээгдэхүүн сорох, даралттай агаар өгөх системийн автоматжуулалт хийх
- Цахилгаан, холбооны шахт байрлал өөрчлөгдсөн, гипсэн хавтангаар хийсэн автор тайлбар албан бичиг өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төв, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга **Д.Батням**:

- Материалын тохирлын гэрчилгээ нөхөж шалгуулах
- БНБДүрмийн хангуулан айл өрхөд ногдох дулаан зогсоолыг шийдвэрлэх
- Нормчлолын сангийн шимтгэл төлөх

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах

Үндэсний төв архив Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Б.Оюунжаргал**:

- Барилгын хувийн хэргийг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- Барилгад хэрэглэсэн бараа материалын сертификат, гарал үүслийн гэрчилгээ, чанарын гэрчилгээг материал, гэрчилгээ тус бүрээр дотоод товъёог хийх
- БУ-н тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж хуудас дугаарлах
- БУ-н ил далд ажлын актыг акт тус бүрээр ажил тус бүрд дотоод товъёог хийх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан **Д.Ганбат**:

- Явган хүний зам нийтийн эзэмшлийн талбай хүрэх налуу замын өндөр байгаа талд хамгаалалтын хашлага бариул хийх
- 1-р давхрын ариун цэврийн өрөөний хаалган дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг тэмдэглэгээ хийх
- Цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний суултуур хооронд хаалт хийх мөн бариул хийх
- Аваарын шатны ханан талд бариул хийх
- Цахилгаан шатыг монгол хэлээр ярьдаг болгох эсвэл давхар бүрийн цахилгаан шатны дэргэдэх хананд брайль тоон тэмдэглэгээ хийх
- Айл бүрийн хаалганы тоог хүртээмжтэй байдлаар буюу брайль тоон тэмдэглэгээ хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай.

Ашиглалт хариуцагч Баганат харш ХХК-ийн гүйцэтгэх захирал **О.Түмэнбаяр:**

- Цэцэрлэгийн халаалтын коллекторуудын хуваарилж биржжүүлэх
- Цэцэрлэг 00 өрөө цэвэр усны хаалтыг таг бүрэн гүйцээж хийх
- Гадна худгуудыг цэвэрлэх
- Айл амьдрах хэсэгт цэвэрлэгээ хийх ус авах цэг, бохир ус татан зайлуулах асуудлыг шийдэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах хүсэлтэй байна.

Зураг төсөл зохиогч Харш Прожект ХХК-ийн захирал **Н.Мөнхбат:**

- Барилгын урд талын нэг цонхны яамка /цонхыг хөрснөөс тусгаарлах бетон хаалт/ хаявчыг гүйцээж цутгах
- Цэцэрлэгийн ангиудын галын шатны ган бүтээцийг дахин будах

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай.

Гүйцэтгэгч Баганат өргөө ХХК-ийн Ерөнхий инженер **Б.Батзаяа:**

Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах

Захиалагч Баганат өргөө ХХК -ийн Төслийн менежер **А.Батнавч:**

Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- БХТ-ийн 14.3, 14.6 дагуу чанарын баталгаа гаргах
- Тагтны хаалтыг гүйцээж дуусгах
- Цэцэрлэгийн халаах хэрэгсэлд хамгаалалт хийх, аваарын гарцанд хаалт хийх
- А, Е айлуудын хаалга мөргөлдөж байгаад тайлбар ирүүлэх /Харш прожект ХХК/
- Цэцэрлэгийн аваарын хаалгын өөрчлөлтийн зураг болон тайлбар ирүүлэх, хамгаалалт хийх

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Баганат өргөө ХХК-ийн захиалгатай, 45 ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 50 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах ашиглалтад оруулах.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Захиалагч Баганат өргөө ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(Б.Тамир)

